




**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2016.06

Үзүүлэлтүүд:


ДНБ 3.2% 2016 оны I-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр	ГШХО 5-р сард 175 сая ам.доллар	Төсвийн алдагдал -1123 тэрбум төгрөг	Инфляци 1.6%	Чанаргүй зээл 1036 тэрбум төгрөг	Валютын нөөц 1.4 тэрбум ам.доллар
Уул уурхайн салбар 130.5 хувь, барилгын салбар 9.4 хувь, хөдөө аж ахуйн салбар 5 хувь тус тус өссөн нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 5-р сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91.3 сая ам.доллар, өмнөх сараас 116.9 сая ам.доллараар өсч 175 сая ам.доллар болов.	Төсвийн орлого 2541.3 тэрбум төгрөг, зарлага 3665.1 тэрбум болж төгрөг, тэнцэл (1123.8) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.	Өмнөх сараас 0.3 хувь буурч, оны эхнээс 2.9 хувь өмнөх оны мөн үеэс 1.6 хувь өссөн байна.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 2.8 хувь буюу 30 тэрбум төгрөгөөр буурч 1036 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.6% байна.	Монголбанкны валютын нөөц 5-р сард өнгөрсөн оны мөн үеэс 9.4 хувь буюу 149 сая ам.доллараар буурч 1442 сая ам.доллар болов.
 Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 1964.93 ₮	 Орон сууцны үнийн индекс 1.023 Өмнөх сараас 1.1%-иар, өмнөх оны мөн үеэс 10.2%-иар тус тус буурлаа.	 Монголбанкны бодлогын хүү 10.5 %			



Жил бүрийн зургаадугаар сарын 1-нийг “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” хэмээн Монгол Улс даяараа өргөн дэлгэр тэмдэглэдэг уламжлалтай. 1950 оноос хойш дэлхийн 50 орчим улс “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” хэмээх уриан дор зургаадугаар сарын 1-ны өдрийг Хүүхдийн баяр болгон тэмдэглэж иржээ.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2013 он		2014 он		2015 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	18,194	1,116,153	19,482	850,615	14,426	555,027
Төмрийн хүдэр	6725	654,333	8,338	448,378	6,325	227,200
Зэсийн баяжмал	650	948,951	1,378	2,575,636	1,379	2,280,135
Нийт	25,569	2,719,437	29,198	3,874,629	22,130	3,062,362

Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар

Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нийт хувьцааны 10 хувийг Монгол Улсын төр ямар нэгэн хөрөнгө оруулалт хийхгүйгээр үнэ төлбөргүй эзэмшихээр тогтоож, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрхийг Аж үйлдвэрийн яаманд олголоо.


Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

ДНБ ДНБ 2016 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 91.3 тэрбум төгрөгөөр өсч эдийн засгийн өсөлт 3.2 хувь болов. ДНБ-ий 3.2 хувиар өсөхөд 130.5 хувиар уул уурхай, олборлох салбар, 9.4 хувиар барилгын салбар, 5 хувиар хөдөө аж ахуйн салбар, 5.4 хувиар үйлчилгээний салбар өссөн нь нөлөөлөв.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ зургаадугаар сард 2541.3 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 3665.1 тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1123.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 589 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 3.7 хувиар буурч, зарлага 15.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.



Валютын ханш

Зургаадугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 61.6 төгрөг буюу 3.2 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад -40 төгрөг буюу 2 хувиар буурч 1964.93 төгрөг болов.



Инфляци

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 6-р сард өмнөх сараас 0.3 хувь буурч, өмнөх оны мөн үеэс 2.9 хувь өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 6-р сард өмнөх сарынхаас 0.3 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УБСЕГ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 5-р сарын байдлаар 1442 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 6 хувь буюу 102 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 9.4 хувь буюу 149 сая ам.доллараар буурсан байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс

2016 оны зургаадугаар сард 5.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.1 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх сарынхаас гүйлгээ 32 тэрбум төгрөг буюу 85.3 хувиар буурч, харин арилжигдсан үнэт цаас 0.6 сая ш буюу 2.2 дахин өсчээ. ТОП-20 дундаж индекс 2016 оны 6 дугаар сард 11452 нэгж болж, өмнөх сарынхаас 569 нэгжээр өсч, өмнөх оны мөн үеийнхээс 3140 нэгжээр буурчээ.



* Монголын хөрөнгийн бирж


Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2016 оны зургаадугаар сарын эцэст 11.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 528.6 тэрбум төгрөг буюу 4.9 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 1146.8 тэрбум төгрөг буюу 11.4 хувиар өсөв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 839 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 51 тэрбум төгрөг буюу 6.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 83.4 тэрбум төгрөг буюу 11 хувиар өсөв.



Хадгаламж

Нийт хадгаламж 2016 оны 6-р сард 7.9 их наяд төгрөг болж өмнөх сараас 141.1 тэрбум төгрөг буюу 1.8 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 602.1 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү, өмнөх оны мөн үеэс нийт хадгаламж өсөхөд валютын хадгаламж 13 хувиар буюу 263 тэрбум төгрөгөөр өсч, төгрөгийн хадгаламж 6.4 хувиар буюу 339.1 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны зургаадугаар сарын байдлаар 12 их наяд төгрөг болж, өмнөх сараас 586 тэрбум төгрөг буюу 5.1%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 70 тэрбум төгрөг буюу 0.6 %-иар өсөв. Харин чанаргүй зээлийн хэмжээ 1036 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 2.8% (30 тэрбум төгрөг)-иар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 33.8% (262 тэрбум төгрөг)-иар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.6%-ийг эзэлж байна.



Ипотекийн зээл

2016 оны 6-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 2.6 хувь (95.2 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 19 хувь (607.4 тэрбум төгрөг)-иар нэмэгдэж нийт 3.7 их наяд төгрөгт хүрэв. Зургаадугаар сард нийт 1626 зээлдэгчид 95.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 84906-д хүрэв. 2016 оны зургаадугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэлийн 99.1 хувь нь төгрөгийн, 0.9 хувь нь валютын зээл байна.




* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа

2016 оны зургаадугаар сард худалдааны нийт бараа эргэлт 3692 сая ам.доллар,үүнээс экспорт 2192 сая ам.доллар, импорт 1499 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 693 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 517 сая ам.доллар буюу 12.2 хувь, үүний дотор экспортын хэмжээ 177 сая ам.доллар буюу 3 хувиар, импортын хэмжээ 339 сая ам.доллар буюу 18 хувиар тус тус буурчээ. Эрдэс бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нь нийт экспортын 85.5 хувийг эзэлж байгаа бол импортын 52.9 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт эзэлж байна.



* Эх сурвалж УБСЕГ, Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2016 оны тавдугаар сард 175 сая ам.долларын эерэг үр дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 91.3 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад 116.9 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.1 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 175.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.




* Эх сурвалж Монголбанк


Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2016 оны нэгдүгээр улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 22.5 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 11 хувь (387 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 5 хувь (995 сая ам.доллар) иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 18 хувийг засгийн газрын өр, 9 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 16 хувийг бусад салбаруудын өр, 48 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 97 хувийг богино хугацаат, 3 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Тэрбум төгрөг

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

- 06.05** Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэнгийн урилгаар АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Кэрри манай улсад айлчлав. Хоёр тал албан ёсны хэлэлцээ хийж хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа иж бүрэн түншлэлийн түвшинд идэвхтэй хөгжиж, дээд, өндөр түвшний айлчлал тогтмолжиж буйг тэмдэглэн хоёр талын улс төр, батлан хамгаалах, эдийн засаг, бүс нутаг болон олон улсын хамтын ажиллагааны тухай санал солилцов.
- 06.09** АСЕМ-ын 11 дүгээр хуралдааны салбар хуралдаан болох Сангийн сайд нарын 12 дахь удаагийн уулзалт “Ази, Европын хөгжлийн төлөөх түншлэл” сэдвийн хүрээнд болов. Тус уулзалтад АСЕМ-ын гишүүн 43 улсын Сангийн сайд болон бусад түвшний төлөөлөл, Европын комисс, эдийн засаг, мөнгөний асуудал эрхэлсэн комиссар нар, ОУВС, Дэлхийн банк, Европын төв банк зэрэг олон улсын байгууллагууд болон Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг 13 олон улсын байгууллагын тэргүүн, олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл бүхий нийт 260 орчим төлөөлөгч оролцов.
- 06.14** Монгол Улс, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2016 оны 6 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад ажлын айлчлал хийлээ.
- 06.23** Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотноо болж буй Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 16 дугаар хуралдааны хүрээнд Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Төрийн тэргүүн нарын гурав дахь удаагийн дээд түвшний уулзалт амжилттай болов.

Тойм

Монгол улс “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан”-д 61 орноос 60-г эрэмбэлэгдлээ.

Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэнгийн дэргэдэх “Дэлхийн өрсөлдөх чадварын төв”-өөс жил тутам эрхлэн гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан”-д Монгол Улс өнгөрсөн жилээс 3 байраар ухарч 61 орноос 60-г эрэмбэлэгдсэн байна. Улс орнуудыг өрсөлдөх чадвараар нь үнэлсэн энэхүү тайланг 1989 оноос хойш эрхлэн гаргаснаас хойш дэлхийн хамгийн өрсөлдөх чадвар бүхий эдийн засагтай АНУ сүүлийн 3 жилд анх удаагаа Хонг Конг болон Швейцарь Улсын дараагаар 3-р байрт эрэмбэлэгдлээ. ЭЗБӨЧСТ-ийн тодорхойсноор “Гадаадын шууд хөрөнгө оруулалт” буурсан нь Монгол Улсын хувьд 2016 онд тулгарах гол сорилтуудын нэг болохоор байгаа бөгөөд 2015 оны эцсийн байдлаар ГШХО-ын хэмжээ 2012 оныхтой харьцуулахад 22 дахин буурсан байна. Ам.долларын эсрэг төгрөгийн ханшийн сулрал нь цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ улс орон даяар сайжруулсан дэд бүтэц хэрэгтэй байгаа хэдий ч энэхүү үйл явцад нэлээдгүй цаг хугацаа хэрэгтэй.

Энэ жил Азийн хэд хэдэн орны өрсөлдөх чадвар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд БНХАУ өнгөрсөн жилээс 3 байраар ухарч 25-р байрт орсон бол ОХУ 1 байраар урагшилж 44-р байрт эрэмбэлэгдлээ. ОУУХХ-ийн дэргэдэх ДӨЧТ-ийн захирал профессор Артуро Брис хэлэхдээ “Өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад Азийн улс орнуудын өрсөлдөх чадвар бүхэлдээ буурсан” гэв.

Өрсөлдөх чадвараар эрэмбэлэхдээ дөрвөн хүчин зүйлийн (эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг болон дэд бүтэц) 340 гаруй шалгуур үзүүлэлтийг ашигладаг. Монгол Улс “Эдийн засгийн тамир тэнхээ”-ээр 2016 онд өмнөх жилээс 4 байраар ухарч 59-р байрт эрэмбэлэгдсэн. Үүнд дотоодын эдийн засаг 54-өөс 59-т, олон улсын хөрөнгө оруулалт 42-оос 49-т, хөдөлмөр эрхлэлт 49-өөс 53-т, үнэ 6-аас 40-р байрт эрэмбэлэгдэж буурсан нь гол нөлөө үзүүлжээ. Монгол Улс ДНБ-ийн хэмжээгээрээ хамгийн сүүлд буюу 61-р байрт байгаа хэдий ч ДНБ-ийн бодит өсөлтөөрөө 33-р байрт орсон байна.